



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Энх элбэрэл” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/065/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 11315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Аудитын менежер: С.Гантөгс  
Утас: 11315558 Цахим хаяг: [gantugss@audit.gov.mn](mailto:gantugss@audit.gov.mn)  
“Ворлдвайд файнэнс Аудит” ХХК-ийн захирал: С.Оюунгэрэл  
Утас: 99032466 Цахим хаяг: [oyungerels.sag@gmail.com](mailto:oyungerels.sag@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.03.13 № 84  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН  
ДҮҮРГИЙН "ЭНХ ЭЛБЭРЭЛ"  
ӨЭМТ-ИЙН ДАРГА Г.ИЧИННОРОВ  
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Энх элбэрэл" ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Энх элбэрэл" ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 27.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх", "үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Энх элбэрэл" ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн

тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 890.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Энх элбэрэл” ӨЭМТ-ийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 28-аар баталж, үйл ажиллагаагаа явуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	15,388,881.99	45,389,433.61
Дансны авлага	48,933,522.37	11,084,678.90
Татвар, НДШ - ийн авлага	125,967.12	174,509.89
Бараа материал	47,044,880.74	41,299,079.80
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>111,493,251.61</b>	<b>97,947,702.20</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	384,184,715.74	334,210,771.53
Биет бус хөрөнгө	28,132,900.00	742,500.00
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>412,317,615.74</b>	<b>334,953,271.53</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>523,810,867.35</b>	<b>432,900,973.73</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
Цалингийн өглөг		174,509.89
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>174,509.89</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>174,509.89</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>265,177,863.87</b>	<b>265,177,863.87</b>
Төрийн	264,177,863.87	264,177,863.87
Хувийн	1,000,000.00	1,000,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	258,633,003.48	167,548,599.97
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>523,810,867.35</b>	<b>432,726,463.84</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>523,810,867.35</b>	<b>432,900,973.73</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Борлуулалтын орлогын дүн</b>		
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
<b>Нийт ашиг (алдагдал)</b>		
Бусад орлого	1,253,811,056.99	910,538,338.10
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	930,672,455.55	1001,622,741.61
Санхүүгийн зардал		
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>323,138,601.44</b>	<b>-91,084,403.51</b>
Орлогын татварын зардал		
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>323,138,601.44</b>	<b>-91,084,403.51</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>323,138,601.44</b>	<b>-91,084,403.51</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</b>	<b>864,989,366.46</b>	<b>947,056,380.87</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	125,443,850.00	187,135,350.00
Татаас, санхүүжилтийн орлого	732,325,016.46	739,326,370.87
Бусад мөнгөн орлого	7,220,500.00	20,594,660.00
<b>Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн</b>	<b>843,282,496.09</b>	<b>906,360,929.25</b>
Ажиллагчдад төлсөн	628,271,954.54	602,888,762.01
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	71,668,180.83	132,314,936.37
Бараа материал худалдан авахад төлсөн	70,394,097.90	70,292,544.00
Ашиглалтын зардалд төлсөн	10,641,208.09	10,753,248.87
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,600,000.00	9,783,800.00
Татварын байгууллагад төлсөн	50,324,322.12	55,206,275.00
Бусад мөнгөн зарлага	2,382,732.61	25,121,363.00
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>21,706,870.37</b>	<b>40,695,451.62</b>
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>	0.00	0.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>8,497,000.00</b>	<b>10,694,900.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	8,497,000.00	10,694,900.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-8,497,000.00</b>	<b>-10,694,900.00</b>
<b>Санхүүгийн мөнгөн гүйлгээ</b>		
<b>Санхүүгийн мөнгөн орлогын дүн</b>		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
<b>Санхүүгийн мөнгөн зарлагын дүн</b>		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
<b>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>13,209,870.37</b>	<b>30,000,551.62</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,179,011.62</b>	<b>15,388,881.99</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>15,388,881.99</b>	<b>45,389,433.61</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	265,177,863.87	-	-	-		-64,505,597.96	200,672,265.91
Зарласан ногдол ашиг		.				-	
Өмчит гарсан өөрчлөлт							
Тайлант үеийн ашиг						323,138,601.44	
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	265,177,863.87	-	-	-		<b>258,633,003.48</b>	<b>523,810,867.35</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт							
<b>Залруулсан үлдэгдэл</b>	265,177,863.87	-	-	-		258,633,003.48	<b>523,810,867.35</b>
Зарласан ногдол ашиг		.				-	
Өмчит гарсан өөрчлөлт						-	
Тайлант үеийн ашиг						-91,084,403.51	<b>-91,084,403.51</b>
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	265,177,863.87	-	-	-		<b>167,548,599.97</b>	<b>432,726,463.84</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 131,643.5 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- ХХОАТ-ын тайлангийн суутгасан татварын дүн болон шилжүүлсэн татварын зөрүү 174.5 мянган төгрөгөөр авлага бүртгүүлсэн.
- Машин тоног төхөөрөмжид бүртгэлтэй 89,544.0 мянган төгрөгийн үнэ бүхий 37 ширхэг компьютер бусад хэрэгслийг "компьютер бусад хэрэгсэл"-д ангилан бүртгүүлж, алдааг залруулсан.
- 2024 онд хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 157,218.8 мянган төгрөгийн өртөгтэй Зөөврийн рентгэн аппарат ашиглагдах нөхцөл хангагдаагүй атал нийт 41,925,0 төгрөгийн элэгдэл байгуулсан алдааг залруулсан.

Эдгээр нь НББОУС 16: Үндсэн хөрөнгө “үндсэн хөрөнгийн анги тус бүрийн ... тайлант хугацааны өөрчлөлтийг тодруулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.42 “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2017 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-т "...Компьютер, бусад хэрэгсэл-ийг ангилан бүртгэнэ", "...Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс буюу түүнийг захиргааны зорилгоор ашиглах нөхцөл хангагдсан үеэс эхлэн элэгдэл тооцно" гэсэн заалтуудыг зарчсөн, санхүүгийн тайлагналын холбогдох батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн 12,169.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup>д 1 төлбөрийн акт тогтоож, 15,513.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж байна.

Залруулагдаагүй 27,682.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

Тайлант жилд нийт 925 өдөр ажилласан цагийн бүртгэлээр нэр бүхий 4 ӨЭМТ-өөс нягтлан бодогч Т.Хажидсүрэнд хоол, унааны хөнгөлөлтөд 9,250.0 мянган төгрөг зарцуулснаас тус ӨЭМТ 1,640.0 мянган төгрөгийг хэтрүүлж, мөн илүү цагийн хөлсөнд 183.3 мянган төгрөг, ажил хавсарсны нэмэгдэлд 11,807.1 мянган төгрөг, нийт 13,630.4 мянган төгрөг олгосон. Үүнээс НДШ болон ХХОАТ-ыг хассан дүнгээр тооцоход 12,169.3 мянган төгрөгийн зөрчилтэй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4-т "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна", тус ӨЭМТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан "хоол, унааны хөнгөлөлтөд 1 хүнд өдөрт 10,000 төгрөг олгох" гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн тухай хууль болон ӨЭМТ-ийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалыг зөрчсөн 12,169.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт

ТОГТООЛОО.

### 3.2 Албан шаардлага

#### Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Нийт 925 өдөр ажилласан цагийн бүртгэлээр нягтлан бодогч Т.Хажидсүрэнд нэр бүхий 4 ӨЭМТ-өөс үндсэн цалинд 77,923.4 мянган төгрөг олгосныг хянахад тус ӨЭМТ хуулиар тогтоосон ажлын цагийн хязгаараас хэтрүүлэн 11,053.2 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4-т "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.13-т "эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах" гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн тухай хуулийг зөрчсөн 11,053.2 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-2: Эрүүл мэндийн даатгалын багцын тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанартай хүргэх, гүйцэтгэх ажилд ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн хуваариар хамааралгүй нягтлан бодогч Т.Хажидсүрэнд 3,300.0 мянган төгрөг, нярав Ө.Бадамцэцэгт 1,160.0 мянган төгрөг, нийт 4,460.0 мянган төгрөгийн ЭМД-ын урамшуулал олгосон байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д "... эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц" гэж даатгуулагчид үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн засах, асрах, сувилах, хөнгөвчлөх болон эмийн үнийн хөнгөлөлтийг багтаасан эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нийцүүлэн урамшууллыг олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх аудитын шийдвэрүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ХХОАТ-ын тайлангийн суутгасан татварын дүн болон шилжүүлсэн татварын зөрүүгээр авлага бүртгээгүй.	1	174.5			1	174.5	1	174.5				

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 37 ширхэг компьютер бусад хэрэгслийг "компьютер бусад хэрэгсэл"-д ангилан бүртгээгүй, машин, тоног төхөөрөмж ангилалд бүртгэсэн.	1	89,544.0			1	89,544.0	1	89,544.0				
2024 онд хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 157,218,825 төгрөгийн өртөгтэй Зөөврийн рентген аппарат ашиглагдах нөхцөл хангагдаагүй атал элэгдэл байгуулж, тайлангийн үеийн үр дүнг бууруулсан.	1	41,925.0			1	41,925.0	1	41,925.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>131,643.5</b>			<b>3</b>	<b>131,643.5</b>	<b>3</b>	<b>131,643.5</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогч Т.Хажидсүрэнд тайлант жилд 925 өдөр ажилласан цагийн бүртгэлээр 4 ӨЭМТ-өөс хоол, унааны хөнгөлөлтөөр 9,250.0 мянган төгрөг, илүү цагийн хөлсөнд 1,700.9 мянган төгрөг, ажил хавсарсны ажил хавсарсны 16,859.4 нийт 27,810.3 мянган олгосныг хянахад тус ӨЭМТ 12,169.3 мянган төгрөгийн зөрчилтэй байна.	1	12,169.3	1	12,169.3				
Нягтлан бодогч Т.Хажидсүрэнд тайлант жилд 925 өдөр ажилласан цагийн бүртгэлээр 4 ӨЭМТ-өөс үндсэн цалинд 77,923.4 мянган төгрөг, мөн 87 өдөр амрахаар 3 ӨЭМТ-өөс 10,504.6 мянган төгрөг олгосныг хянахад тус ӨЭМТ 11,053.2 мянган төгрөгийн зөрчилтэй байна.	1	11,053.2			1	11,053.2		
Эрүүл мэндийн даатгалын багцын тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанартай хүргэж, гүйцэтгэх ажилд ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн хуваариар хамааралгүй атал нягтлан бодогч Т.Хажидсүрэн 3,300.0 мянган төгрөг, нярав Ө.Бадамцэцэг 1,160.0 мянган төгрөг нийт 4,460.0 мянган төгрөгийн ЭМД-ын урамшуулал авсан байна.	1	4,460.0			1	4,460.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>27,682.5</b>	<b>1</b>	<b>12,169.3</b>	<b>2</b>	<b>15,513.2</b>		

